ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Усны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/262/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

**Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**
Утас: 51-261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: Э.Энхбаатар**
Утас: 51-260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn
**Ахлах аудитор: Г.Мөнхчимэг**
Утас: 51-261628 Цахим хаяг: Munkhchimegg@audit.gov.mn
**Аудитор: Ч.Мөнхбулган**
Утас: 51-261628 Цахим хаяг: Munkhbulganch@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 07/1181

танай ____________-ны №____________-т

УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАТБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Усны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийг зохистой удирдаагүйгээс 4,538.6 мянган төгрөгийн авлага үүсгэсэн, тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, санхүүжилтийг дээд шатны байгууллагын тушаал шийдвэргүйгээр барьцаа дансанд төвлөрүүлсэн 400,000.0 мянган төгрөг, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0314 SNAG-10.Docx

1525071010

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Засгийн газрын 2024 оны 110 дугаар "Төсвийн төвлөрүүлэн захирагчийг шинэчлэн батлах тухай" тогтоолоор Усны газар нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас хасагдсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

"Усны нөөц, нуур, гол мөрний менежмент" хөтөлбөр арга хэмжээнд 5,079,174.4 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 4,600,055.2 мянган төгрөгийг зарцуулж, 479,119.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудал**

Тайлант онд усны мэдээллийн нэгдсэн "Ewater" системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, төрийн үйлчилгээг хурдан шуурхай иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүртээмжтэй ил тод болгосон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамаараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2025\0314 SNAG-10.Docx

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **594,643,796.64** | **583,830,020.29** |
| **33** | **АВЛАГА** | **312,550,320.00** | **510,626,055.29** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 4,538,639.29 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 312,550,320.00 | 506,087,416.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **-** | **9,500,000.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 9,500,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **282,093,476.64** | **63,703,965.00** |
| **35100** | **Түүхий эд материал** | **10,053,980.00** | **10,701,950.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 10,053,980.00 | 10,701,950.00 |
| 35200 | Дуусгаагүй үйлдвэрлэл | 235,168,500.00 | - |
| **35400** | **Хангамжийн материал** | **36,870,996.64** | **53,002,015.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 321,600.00 | 200,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 34,273,940.64 | 52,072,969.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,275,456.00 | 728,846.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,860,189,387.50** | **4,263,244,062.72** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,860,189,387.50** | **4,263,244,062.72** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **3,375,898,943.21** | **3,021,944,962.80** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,269,061,506.18 | 1,269,061,506.18 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (118,944,612.35) | (150,230,125.71) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 464,350,829.90 | 519,350,829.90 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (108,674,616.19) | (186,211,528.09) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 2,362,516,075.34 | 2,372,831,041.38 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (562,121,415.87) | (904,068,623.32) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 88,345,393.47 | 133,576,090.93 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (18,634,217.27) | (32,364,228.47) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **1,484,290,444.29** | **1,241,299,099.92** |
| 39301 | Программ хангамж | 1,343,800.00 | 3,879,666.86 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (765,029.79) | (1,160,583.06) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,503,904,190.00 | 2,803,261,710.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (1,020,192,515.92) | (1,564,681,693.88) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,454,833,184.14** | **4,847,074,083.01** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,454,833,184.14** | **4,847,074,083.01** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **5,454,833,184.14** | **4,847,074,083.01** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | **257,921,878.13** | **257,921,878.13** |
| 51101 | Өмч: -төрийн | 257,921,878.13 | 257,921,878.13 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **5,196,911,306.01** | **4,589,152,204.88** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 5,777,674,788.25 | 5,196,911,306.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (580,763,482.24) | (607,759,101.13) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,454,833,184.14** | **4,847,074,083.01** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,497,485,704.93** | **9,631,756,152.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,035,597,948.93** | **636,323,749.71** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,035,597,948.93** | **636,323,749.71** |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **1,035,597,948.93** | **636,323,749.71** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 770,030,452.43 | 525,792,672.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 265,567,496.50 | 110,531,077.71 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,461,887,756.00** | **8,995,432,402.85** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **3,930,373,735.00** | **7,523,735,161.85** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,509,837,200.00 | 4,553,381,711.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 1,420,536,535.00 | 2,970,353,450.85 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **531,514,021.00** | **1,471,697,241.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 33,834,550.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 111,532,500.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 386,146,971.00 | 1,471,697,241.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **6,030,612,700.00** | **9,678,827,140.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,340,724,343.00** | **7,204,561,105.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,696,734,356.43** | **5,720,349,413.86** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **703,011,978.49** | **1,088,761,507.65** |
| 210101 | Үндсэн цалин | 391,108,440.32 | 650,592,912.89 |
| 210102 | Нэмэгдэл | 144,250,778.17 | 143,371,293.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 102,682,000.00 | 181,114,000.00 |
| 210104 | Урамшуулал | 64,970,760.00 | 94,949,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 18,734,301.76 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **89,161,415.40** | **132,006,486.13** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,103,442.24 | 86,820,004.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,144,229.39 | 10,864,301.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,949,414.90 | 9,254,741.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,103,638.47 | 5,013,487.78 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,860,690.40 | 20,053,950.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **22,423,795.04** | **44,013,349.86** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,047,175.33 | 16,261,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,803,902.47 | 13,745,849.86 |
| 210304 | Байрны түрээс | 4,572,717.24 | 14,006,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **121,813,824.35** | **79,538,181.47** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,349,800.00 | 15,118,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,758,696.00 | 32,371,460.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,125,875.18 | 9,548,399.83 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 59,898,332.76 | 22,499,921.64 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 26,681,120.41 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **44,421,354.80** | **68,926,120.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 44,421,354.80 | 68,926,120.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **74,710,460.00** | **119,718,490.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 47,034,460.00 | 89,019,790.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 8,347,400.00 | 12,710,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,328,600.00 | 17,988,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **32,056,690.00** | **52,894,700.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 32,056,690.00 | 52,894,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,831,441,168.75** | **3,088,686,819.40** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,466,816,395.50 | 3,082,909,065.40 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 85,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,154,930.00 | 70,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 350,484,843.25 | 791,054.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 149,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,933,000.00 | 2,800,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,818,000.00 | 2,116,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **777,693,669.60** | **1,045,803,759.35** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 777,693,669.60 | 1,044,803,759.35 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **643,989,986.57** | **1,484,211,691.84** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **173,447,000.00** | **899,390,823.56** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 107,097,000.00 | 44,156,883.56 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 66,350,000.00 | 855,233,940.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **470,542,986.57** | **584,820,868.28** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 460,732,450.57 | 479,119,227.28 |
| 213304 | Хөрөнгийн | 4,709,615.00 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 5,100,921.00 | 105,701,641.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,689,888,357.00** | **2,474,266,034.85** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **1,689,888,357.00** | **2,474,266,034.85** |
| 220001 | Барилга байгууламж | 1,689,888,357.00 | 2,474,266,034.85 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(533,126,995.07)** | **(47,070,987.99)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **47,636,487.17** | **560,688,113.14** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | **47,636,487.17** | **560,688,113.14** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (IV)=(145-225)** | **(47,636,487.17)** | **(560,688,113.14)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(580,763,482.24)** | **(607,759,101.13)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,679,244,208.43** | **9,664,839,586.85** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,141,280,452.43** | **669,407,184.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,141,280,452.43** | **669,407,184.00** |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **770,030,452.43** | **525,792,672.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 770,030,452.43 | 525,792,672.00 |
| 120009 | Бусад орлого | 371,250,000.00 | 143,614,512.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,537,963,756.00** | **8,995,432,402.85** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **3,930,373,735.00** | **7,523,735,161.85** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,509,837,200.00 | 4,553,381,711.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 1,420,536,535.00 | 2,970,353,450.85 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **607,590,021.00** | **1,471,697,241.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 33,834,550.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 111,532,500.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 462,222,971.00 | 1,471,697,241.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,669,079,788.43** | **6,145,174,974.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,669,079,788.43** | **6,145,174,974.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,025,089,801.86** | **4,660,963,282.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **703,011,978.49** | **1,088,761,507.65** |
| 210101 | Үндсэн цалин | 442,138,319.50 | 657,245,192.00 |
| 210102 | Нэмэгдэл | 109,902,900.00 | 150,033,707.89 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 85,999,998.99 | 168,003,600.00 |
| 210104 | Урамшуулал | 64,970,760.00 | 94,744,706.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 18,734,301.76 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **89,161,415.40** | **136,545,125.42** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,053,790.52 | 91,754,160.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,138,387.47 | 10,864,301.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,671,109.19 | 5,940,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,390,738.16 | 5,940,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,907,390.06 | 22,045,463.17 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **22,423,795.04** | **44,013,349.86** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,047,175.33 | 16,261,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,803,902.47 | 13,745,849.86 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,572,717.24 | 14,006,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **40,591,375.18** | **70,197,149.83** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,001,500.00 | 6,797,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,462,500.00 | 30,324,850.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,488,875.18 | 9,548,399.83 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,638,500.00 | 23,526,900.00 |
| **2105** | **Нормативд зардал** | **44,580,760.00** | **74,194,090.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 44,580,760.00 | 74,194,090.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **245,036,619.00** | **85,870,540.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 204,747,619.00 | 59,791,840.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 8,570,400.00 | 8,090,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 31,718,600.00 | 17,988,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **25,553,200.00** | **52,894,700.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 25,553,200.00 | 52,894,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,854,730,658.75** | **3,107,486,819.40** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,412,829,885.50 | 3,101,709,065.40 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 85,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,154,930.00 | 70,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 350,484,843.25 | 791,054.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 149,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 88,209,000.00 | 2,800,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,818,000.00 | 2,116,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **1,000,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **643,989,986.57** | **1,484,211,691.84** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **173,447,000.00** | **899,390,823.56** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 107,097,000.00 | 44,156,883.56 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 66,350,000.00 | 855,233,940.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **470,542,986.57** | **584,820,868.28** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 460,732,450.57 | 479,119,227.28 |
| 213304 | Хөрөнгийн | 4,709,615.00 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 5,100,921.00 | 105,701,641.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **2,010,164,420.00** | **3,519,664,612.85** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **2,010,164,420.00** | **3,376,050,100.85** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,010,164,420.00** | **3,376,050,100.85** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **2,010,164,420.00** | **3,376,050,100.85** |
| 220001 | Барилга байгууламж | 1,415,826,920.00 | 2,970,353,450.85 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 594,337,500.00 | 405,696,650.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(2,010,164,420.00)** | **(3,376,050,100.85)** |
| **25** | **Санхүүгийн үйл ажиллагааны зардал** | **-** | **143,614,512.00** |
| 250006 | Бусад зардал | - | 143,614,512.00 |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **(143,614,512.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-** | **-** |
| **IX** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **X** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **257,921,878.13** | **5,777,674,788.25** | **6,035,596,666.38** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | **-** | **-** | **-** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **257,921,878.13** | **5,777,674,788.25** | **6,035,596,666.38** |
| Тайлант үеийн үр дүн | **-** | (580,763,482.24) | (580,763,482.24) |
| **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **257,921,878.13** | **5,196,911,306.01** | **5,454,833,184.14** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **257,921,878.13** | **5,196,911,306.01** | **5,454,833,184.14** |
| Тайлант үеийн үр дүн | - | (607,759,101.13) | (607,759,101.13) |
| **2024 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл** | **257,921,878.13** | **4,589,152,204.88** | **4,847,074,083.01** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,366,976,200.00** | **4,600,055,155.72** | **1,184,624,744.28** | **79.5** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,366,976,200.00** | **4,600,055,155.72** | **1,184,624,744.28** | **79.5** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,322,818,900.00** | **4,555,898,272.16** | **1,184,624,327.84** | **79.4** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,186,992,500.00** | **1,088,761,507.65** | **98,230,992.35** | **91.7** |
| Үндсэн цалин | 693,992,400.00 | 657,245,192.00 | **36,747,208.00** | **94.7** |
| Нэмэгдэл | 188,318,000.00 | 150,033,707.89 | **38,284,292.11** | **79.7** |
| Унаа хоолны хөнгөлөлт | 180,916,700.00 | 168,003,600.00 | **12,913,100.00** | **92.9** |
| Урамшуулал | 103,465,400.00 | 94,744,706.00 | **8,720,694.00** | **91.6** |
| Гэрээт ажлын хөлс | 20,300,000.00 | 18,734,301.76 | **1,565,698.24** | **92.3** |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **148,512,000.00** | **136,545,125.42** | **11,967,174.58** | **91.9** |
| Тэтгэврийн даатгал | 100,988,000.00 | 91,754,160.79 | **9,234,139.21** | **90.9** |
| Тэтгэмжийн даатгал | 11,881,000.00 | 10,864,301.46 | **1,016,698.54** | **91.4** |
| ҮОМШӨ-ний даатгал | 5,940,600.00 | 5,940,600.00 | **-** | **100.0** |
| Ажилгүйдлийн даатгал | 5,940,600.00 | 5,940,600.00 | **-** | **100.0** |
| Эрүүл мэндийн даатгал | 23,761,800.00 | 22,045,463.17 | **1,716,336.83** | **92.8** |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **44,013,400.00** | **44,013,349.86** | **50.14** | **100.0** |
| Гэрэл, цахилгаан | 16,261,400.00 | 16,261,400.00 | **-** | **100.0** |
| Түлш, халаалт | 13,745,900.00 | 13,745,849.86 | **50.14** | **100.0** |
| Цэвэр, бохир ус | 14,006,100.00 | 14,006,100.00 | **-** | **100.0** |
| **Хангамж, бараа материалын зардал** | **67,157,300.00** | **67,157,149.83** | **150.17** | **100.0** |
| Бичиг хэрэг | 6,797,000.00 | 6,797,000.00 | **-** | **100.0** |
| Тээвэр, шатахуун | 27,285,000.00 | 27,284,850.00 | **150.00** | **100.0** |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,548,400.00 | 9,548,399.83 | **0.17** | **100.0** |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 23,526,900.00 | 23,526,900.00 | **-** | **100.0** |
| **Нормативт зардал** | **20,000,000.00** | **19,965,280.00** | **34,720.00** | **99.8** |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 20,000,000.00 | 19,965,280.00 | **34,720.00** | **99.8** |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **53,545,600.00** | **53,544,340.00** | **1,260.00** | **100.0** |
| Багаж, техник, хэрэгсэл | 27,466,900.00 | 27,465,640.00 | **1,260.00** | **100.0** |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 8,090,700.00 | 8,090,700.00 | **-** | **100.0** |
| Урсгал засвар | 17,988,000.00 | 17,988,000.00 | **-** | **100.0** |
| **Томилолт, зочны зардал** | **39,481,300.00** | **39,424,700.00** | **56,600.00** | **99.9** |
| Дотоод албан томилолт | 39,481,300.00 | 39,424,700.00 | **56,600.00** | **99.9** |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,762,116,800.00** | **3,105,486,819.40** | **1,074,333,380.60** | **74.3** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,756,338,900.00 | 3,099,709,065.40 | **1,074,333,234.60** | **74.3** |
| Даатгалын үйлчилгээ | 70,000.00 | 70,000.00 | **-** | **100.0** |
| Тээврийн хэрэгслийн татвар | 791,100.00 | 791,054.00 | **46.00** | **100.0** |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,800,000.00 | 2,800,000.00 | **-** | **100.0** |
| Газрын төлбөр | 100.00 | - | **-** | **-** |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,116,700.00 | 2,116,700.00 | **-** | **100.0** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** | **-** | **100.0** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,000,000.00 | **-** | **100.0** |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **44,157,300.00** | **44,156,883.56** | **416.44** | **100.0** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **44,157,300.00** | **44,156,883.56** | **416.44** | **100.0** |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 44,157,300.00 | 44,156,883.56 | **416.44** | **100.0** |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5,366,976,200.00** | **4,600,055,155.72** | **766,921,044.28** | **85.7** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **4,886,914,200.00** | **4,074,262,483.72** | **812,651,716.28** | **83.4** |
| Улсын төсвөөс санхүүжих | 4,886,914,200.00 | 4,074,262,483.72 | **812,651,716.28** | **83.4** |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **480,062,000.00** | **525,792,672.00** | **(45,730,672.00)** | **109.5** |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 480,062,000.00 | 525,792,672.00 | **(45,730,672.00)** | **109.5** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | **-** | **-** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | **-** | **-** |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **77** | **71** | **-** | **-** |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | **100.0** |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **38** | **35** | **-** | **100.0** |
| Удирдах ажилтан | **6** | **5** | **-** | **83.3** |
| Гүйцэтгэх ажилтан | 31 | 28 | **-** | **90.3** |
| Үйлчлэх ажилтан | 1 | 2 | **(1)** | **200.0** |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **38** | **38** | **-** | **100.0** |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 31 | 31 | **-** | **100.0** |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 7 | 7 | **-** | **100.0** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *|төгрөгөөр|*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **1,471,697,241.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,471,697,241.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **510,761,660.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **3,040,000.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | | **3,040,000.00** |
| **2105** | **Нормативт зардал** | | **54,228,810.00** |
| 210503 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | **54,228,810.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **438,022,850.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | **438,022,850.00** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **13,470,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | **13,470,000.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **2,000,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | **2,000,000.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **960,935,581.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 855,233,940.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 855,233,940.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 105,701,641.00 |
| 213305 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | | 105,701,641.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **1,471,697,241.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **1,471,697,241.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 1,471,697,241.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **-** |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**3.1** Аудитаар нийт 384,276.8 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулсан.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүн 143,614.5 мянган төгрөгөөр Санхүү байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн дүнгээс зөрүүтэй илэрхийлсэн. | 1 | 143,614.5 | | | 1 | 143,614.5 | 1 | 143,614.5 | | | | |
| Санхүү байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн элэгдлийн дүнгээс 240,662.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн. | 1 | 240,662.3 | | | 1 | 240,662.3 | 1 | 240,662.3 | | | | |
| **Дүн** | **2** | **384,276.8** | | | **2** | **384,276.8** | **2** | **384,276.8** | **-** | **-** | **-** | **-** |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**3.2** Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 451,336.6 мянган төгрөгийн 6 зөрчил[2] илэрснээс, 4,538.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 446,798.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд оны эцэст Нийгмийн даатгалын 4,538.6 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. | 1 | 4,538.6 | 1 | 4,538.6 | | | | | | | | |
| Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн Аудитын байгууллагад аудит хийлгүүлэхээр хүргүүлсэн жилийн эцсийн санхүүгийн тайланд урсгал төсвийн болон төсвийн тохируулгын тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Тайлант онд гадаад албан томилолттой холбоотой БОУАӨС-ын 2024 оны А/735 дугаар тушаалаар баталсан ОХУ-ын Москва хотын томилолтын бүрэлдэхүүнд орсон тус байгууллагатай холбоо, хамааралгүй нэг иргэний гадаад томилолтын тийзийн зардалд 13,229.0 мянган төгрөг, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны А/119 дугаар тушаалаар "Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай Монгол улс, | 1 | 21,808.8 | | | 1 | 21,808.8 | | | | | | |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн уулзалтад Монголын талаас оролцох төлөөлөгчдийг батлахдаа эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр өөрөө өөртөө томилолтын тушаал гарган шилжүүлсэн 8,579.8 мянган төгрөг, нийт 21,808.8 мянган төгрөгийг олгосон байна. | | | | | | | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын илтгэх хуудаст хөрөнгийн бүрэн бүтэн байдал болон эвдрэл гэмтэлтэй хөрөнгийн талаар мэдээлэл тусгаагүй, санхүүгийн программд үндсэн хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн загвар, нэр, төрөл, байршил, хариуцах эзэн болон хөрөнгөтэй холбогдох мэдээллүүдийг ижил нэршлээр дутуу кодлон бүртгэсэн, хөрөнгө тус бүрд тухайн хөрөнгийн QR кодыг бүртгэн тэмдэглээгүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрөөс гэрээгээр ажил гүйцэтгэсэн 1 аж ахуйн нэгж байгууллагын гэрээний тусгай нөхцөлд гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх чанарын баталгааг байршуулахаар тусгасан боловч нийт 24,989.2 мянган төгрөгийн чанарын баталгааг барьцаа дансанд төвлөрүүлэлгүйгээр санхүүжилтийг бүрэн олгож, тоног төхөөрөмж, хөрөнгийг барьцаа болгон авсан байна. | 1 | 24,989.2 | | | 1 | 24,989.2 | | | | | | |
| Усны газрын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Өгий нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төсөл"-ийн 2 дугаар үе шатны ажлын 3 дугаар багцын тендер шалгаруулалтад гүйцэтгэх санал | 1 | 400,000.0 | | | 1 | 400,000.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ирээгүй тендер шалгаруулалт амжилтгүй болсон ч 2024 оны санхүүжилтийн 400,000.0 мянган төгрөгийг тушаал шийдвэргүйгээр барьцаа дансанд шилжүүлсэн байна. | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **6** | **451,336.6** | **1** | **4,538.6** | **4** | **446,798.0** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 14,646.9 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш цалингийн зардлаас бусад үнийн дүн бүхий орлогын 14,646.9 мянган төгрөгийг илүү мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. | 1 | 14,646.9 | | | 1 | 14,646.9 |
| **Нийт дүн** | **1** | **14,646.9** | | **-** | **1** | **14,646.9** |